



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 180

Улаанбаатар хот

НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДАА ЗОХИОН
БАЙГУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ТУХАЙ

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 106,473,249.33 (нэг зуун зургаан сая дөрвөн зуун далан гурван мянга хоёр зуун дөчин есөн төгрөг гучин гурван мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий 3 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Батгэрэл, "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Нямсамбууд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Худалдсан автомашины улсын дугаарыг шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ

000346



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны... дугаар сарын...-ны өдрийн
10... дугаар тогтоолын хавсралт

"ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Суудлын автомашины марк, улсын дугаар, арал	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Ланд круйзер 80, 24-28 УНИ, FZJ800151813	2004.01.01	ш	1	20,000,000.00	20,000,000.00	-	2,700,000.00
2	Ланд круйзер 100, 14-41 УБЦ, JTECJ09J305509567	2004.01.01	ш	1	66,394,657.48	66,394,657.48	-	3,500,000.00
3	Фургон УАЗ 22069-033, 57-28 ГСА, 60403386	2006.02.01	ш	1	20,078,591.85	20,078,591.85	-	1,000,000.00
Нийт дүн					106,473,249.33	106,473,249.33	-	7,200,000.00
					(нэг зуун зургаан сая дөрвөн зуун далан гурван мянга хоёр зуун дөчин есөн төгрөг гучин гурван мөнгө)			(долоон сая хоёр зуун мянган)